

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-11</i>

1. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.04.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	3-11
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 04 дүгээр сарын 04-ний өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 30 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ч.Хүрэлбаатар, Б.Энхбаяр;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Т.Доржханд.

Нэг.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.04.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын мэргэжилтэн Б.Агиймаа, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Х.Ганхуяг, М.Оюунчимэг, Ц.Цэрэнпунцаг нарын тавьсан асуултад “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал үг хэлэв.

Ц.Цэрэнпунцаг: Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 32 минут үргэлжилж, 18 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 77.8 хувийн ирцтэйгээр 11 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим,
10 цаг 30 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өглөөний амар амгаланг эрвэ.

Ингээд хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя. Дамбын Батлут гишүүн өвчтэй байна. Тогмидын Доржханд гишүүн өвчтэй. Ингээд бусад гишүүд хүрэлцэн ирж Байнгын хорооны гишүүдийн ирц 55,6 хувьтай бүрэлдэж, Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 04 сарын 04-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг асуудал байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд. Засгийн газар 2024 оны 04 сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх гэсэн асуудлыг Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуралдаанаар яаралтай хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан танилцуулна. Амарбаясгалан сайдын микрофоныг нээе. Ажлын хэсгийн 5 номер.

Д.Амарбаясгалан: Эрхэм Байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш шударга хүртээхэд чиглэнэ. Мөн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж байгалийн баялаг түүний дотор газрын хэвлийн баялгийг ашиглах суурь зарчмыг баталгаажуулсан.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор газрын хэвлийн баялаг ашигласны орлогоос Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, түүнийг санхүүгийн үр ашиг бүхий төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, үнэт цаас гаргах зэргээр арвижуулах, эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангах, шударгаар хуваарилах зарчмыг баримтлах зэрэг агуулгаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Сүүлийн 30 орчим жилийн хугацааны үзүүлэлтээс үзвэл Монгол

Улсын нийгэм эдийн засаг нь байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялаг, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын нөөц ашигласны үр өгөөжөөс бүрэн хараат байсан нь харагддаг. Тухайлбал, эрдэс баялгийн салбарын орлого нь 2020 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн 25,7 хувийг, 2021 онд 28,9 хувийг, 2022 онд 35,1 хувийг, 2023 онд 33,3 хувийг бүрдүүлж байв. Эрдэс баялгийн салбарын орлогыг өнөө ба ирээдүйн иргэдэд хүртээх, хуваарилах зорилгоор Хүний хөгжил сангийн тухай хууль, Ирээдүй өв сангийн тухай хууль тогтоомжууд мөн Улсын Их Хурал, Засгийн газраас олон тооны бодлого, хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж байгаа хэдий ч тэдгээр нь байгалийн баялгийн орлогоос өнөө ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх зарчмыг зохистой хэрэгжүүлж чадаагүй өнөөдрийг хүрсэн байна.

Иймд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх замаар тэгш, шударга хүртээх, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулан танилцуулж байна.

Хуулийн төсөлд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлэх, төрөлжсөн сангаар дамжуулан одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хуваарилах, хөрөнгийн удирдлагын тогтолцоо бүхий санг Үндэсний баялгийн сан гэж тодорхойлсон. Үндэсний баялгийн сан нь Ирээдүй өв сан, Хөгжлийн сан, Хуримтлалын сан гэсэн төрөлжсөн сантай байхаар зааж, сангийн эх үүсвэр, хуваарилалт Үндэсний баялгийн сангийн талаар Улсын Их Хурал, Засгийн газар сангийн удирдлагыг хэрэгжүүлэх байгууллагын эрх үүргийн талаар тусгасан болно.

Хуулийн төслийг боловсруулахдаа бусад улс орны баялгийн сангийн

тогтолцоо, зохицуулалтыг судлан үзэж, олон улсын сайн жишигийг харгалзан үндэсний онцлогт тохирсон Үндэсний баялгийн сангийн зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Төсвийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай, Ирээдүй өв сангийн тухай, Ашигт малтмалын тухай, ААНОАТ-ын тухай зэрэг 8 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд стратегийн ач холбогдол бүхий ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хувьцаа эрхээ өв залгамжлах бэлэглэх хэлбэрээр шилжүүлсэн тохиолдолд 30 хувийн татвар ноогдуулахаар тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар байгалийн баялаг түүний дотор газрын хэвлийн баялгийн үр өгөөжөөс бүрдүүлсэн үндэсний баялгийн сангаар дамжуулан байгалийн баялгийг ард түмний мэдэлд байх Үндсэн хуулийн суурь зарчим хангагдана.

Ирээдүй сангаар дамжуулан ирээдүй үеийн иргэн бүрд тэгш хүртээх хуримтлалыг бий болгоно.

Хөгжлийн сангаар дамжуулан хөгжлийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлснээр олон тулгуурт эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах, суурь бүтцийг бий болгосноор түүний үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүр тэгш хүртэх боломж бүрдэнэ.

Хуримтлалын сангаар дамжуулан одоо үеийн иргэн бүрийн эрүүл мэнд, боловсрол, орон сууцын суурь хэрэгцээг хангах хөтөлбөрүүд хэрэгжүүлснээр иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах

эрхийг баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Амарбаясгалан сайдад баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Дашизэвэгийн Амарбаясгалан Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Чулуунбаатарын Дондогмаа ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Батмөнхийн Агиймаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын мэргэжилтэн, Ганхуягийн Давааням МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, Хууль зүйн ухааны доктор, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер.

Хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Хуулийн төслийг бол дэмжиж байна. Энэ бол хийгдэх ёстой ажил. Энэ маш их олон хувилбараар ярьсан л даа. Наранцогт мэдэж байгаа, бид нар их олон юугаар бодсон, ярьсан. Тэгээд яг энэ Засгийн газрын яг өнөөдрийн оруулж ирж байгаа энэ хувилбар бол эхний ээлжид яг ийм хэлбэрээр явчих нь зүйтэй гэж ингэж үзэж байгаа.

Баялгийн санг үүсгэдэг гол эх үүсвэрүүд маань юу вэ гэхээр төрийн өмчтэй болон төрийн өмч давамгайлсан энэ компаниудаас бий болно гэж ингэж үзэж байгаа. АМНАТ бол энэ баялгийн сангийн гол эх үүсвэрүүдийн нэг болно

гэж ингэж үзэж байгаа. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой ААН-үүдийн татварын дараах ашигаас тодорхой хэмжээний хуримтлалуудыг бий болгох гээд энэ санаанууд нь зүйтэй байна гэж.

Төрөлжсөн сангууд 3 сангаар оруулж ирж байна. Энэ эхний ээлжид бол болох байх. Энд бол Ирээдүйн өв сан гэж байна. Хөгжлийн сан байна. Хуримтлалын сан гээд. Тэгэхээр энэ гол санаа бол юу гэхээр зэрэг Ирээдүйн өв сан, Хөгжлийн сангууддаа хуримтлалуудаа нэлээн сайн үүсгээд, тэр хуримтлалын сан хуваарилах юм руугаа тодорхой эх үүсвэрүүд бий болсных нь дараа нэлээн сайн ажиллуулж өгөх нь зүйтэй гэж ингэж бодож байгаа.

Ямар ч тохиолдол бол энэ сангийн хөрөнгө нь нийт ард түмний мэдэлд байна аа гэж байгаа юм. Энэ бол маш их зөв концепт гэж ингэж үзэж байгаа. Ард түмэн юу гэхээр баялгийн сангийн эзэд байна аа гэж.

Улсын Их Хурал болон Засгийн газрын эрх үүргүүдийг бол тодорхой заачихсан байгаа. Энд үүсэж тооцоноос гадна бас нэмэгдэл эх үүсвэрүүдийг бас бид дайчлах ёстой. Тухайлбал, төрийн өмчтэй компаниуд дээр нэлээн их эх үүсвэрүүд байна. Тухайлбал жишээлбэл Эрдэнэтийн бид олон жил ярьсан тэр овоолго гээд асуудал байгаа. Үүнийг тодорхой хэмжээнд үнэлж, тэр энэ баялгийн сандаа төвлөрүүлэх шаардлагатай.

2 дугаарт нь, энэ Оюутолгой дээр бас их хэмжээний овоолго байгаа. Нэгэнт 34 хувийг нь бид нар эзэмшиж байгаа юм бол Оюутолгой компанитай хамтарч энэ дээр үйлдвэр байгуулах эсвэл 34 хувь дээрээ ноогдох үйлдвэрийг Монголын талаас байгуулах ч ийм боломжууд байгаа гэх мэтийн энэ зүйлүүдийг хийх ёстой. Нэмэгдэл эх үүсвэрүүдийг бас бид их олон талаас нь

бодох ёстой гэж бас бусад бусад эх үүсвэрүүд бас байгаа.

Хуримтлалын сан бол зүйтэй. Одоо ард түмнийхээ амьдралыг дээшлүүлэх шаардлагатай. Ерөөсөө Монголын хөгжлийн гарц бол баялгийнхаа менежментийг зөв хийх шаардлагатай. Бур их олон гарцыг бид одоохондоо эхний нэг 5 жил ч юм уу, 10 жилийн хугацаанд бол харагдахгүй байх. Баялгийнхаа менежментийг зөв хийх ёстой. Баялгаа тэр дэлхийн зах зээл болон бүс нутгийн зах зээлийн үнэд хүргэж худалдах ёстой. Энд бол нэг зүйлийг ярихад юу вэ гэхээр энэ баялаг маань бид бүс нутгийн болон дэлхийн зах зээлийн үнэд хүрэхгүй байгаад байгаа шүү дээ. Зөвхөн нүүрс дээр гэхэд л ОХУ-ын Хятадад нийлүүлж байгаа нүүрснээс 20 хувиар хямд, Австралийн нүүрснээс 50 хувиар хямд байж байгаа шүү дээ. Тэгээд бид нар чинь нөгөө хямд үнэ барьдаг энэ бодлогоор яваад байна гэхээр бас тийм биш. Биржээр арилжиж байгаа, биржийн ач тус бол аман дээрээс худалдсанаас хэд дахин илүү ашигтай ийм ажил болоод явж байгаа юм.

Тийм учраас бол энэ санг бид нар ингээд Сангийн хуулийг Баялгийн сангийн хуулийг баталж, тэгээд энэ сантай болох ёстой. Ер нь бол тооцоогоор дэлхийн хэмжээнд 456 баялгийн сан байгаа. Ер нь бол хамгийн идэвхтэй үйл ажиллагаа явж байгаа нь өнөөдөр 170 орчим сан байна. Энэ сангууд юу вэ гэхээр Хятадын хөгжлийн сан, Норвегийн тэтгэврийн сан, Казахстаны хөгжлийн сан гээд их идэвхтэй сайн ажиллаж байгаа ийм сангууд бол байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүн санал хэллээ. Ингээд Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Яах вэ, энэ хэд хэдэн асуулт байна.

1 дүгээрт, энэ ашигт малтмалын тусгай зөвшөөрөл ишилжүүлэх тохиолдолд 30 хувь гэсэн байна л даа. Орлого бүрдүүлбэр дээр нь. Одоо ер нь хэд байгаа юм, нэмэгдээд байгаа юм уу, хасагдаад байгаа юм уу гэдэг нэг хариулт авчихмаар байна.

2 дугаарт, энэ Улс төрийн намын тухай хууль хөндсөн байх юм. Энэ ямар өөрчлөлт орж байгаа юм гэдэг дээр хариулт авчихмаар байх юм. Улс төрийн намын тухай хуулийн 34 дүгээр заалтыг хөндсөн байх юм.

4-д болохоор энэ Хуримтлалын сан нь Нийгэм хамгааллын яамны бүрэн эрхт хамаарах юм байна л даа. Тэгэхээр бид нар Нийгмийн хамгааллын яам дээр нэг зөвлөл гэж нэг юм байгаад байгаа юм. Энэ 3 талт хэлэлцээр хийдэг. Ажил олгогч, нөгөө үйлдвэрчний эвлэл тэгээд ЗГ гээд. Тэрийг нь Нийгмийн хамгааллын яам хариуцдаг. Одоо манай Нийгмийн даатгалын хууль тэр бол маш их бухимдалтай байна. Хөдөлмөрийн хууль дээр маш их бухимдалтай байна. Тэгээд яагаад вэ гээд нөгөө хувийн хэвшлийнхэнтэй уулзахаар үгүй ээ, үгүй бид нарыг төлөөлдөг байгууллага нь төлөөлөх байгууллага нь ороогүй байна. Тухайлбал гэж байгаад тэр Ажил олгогч эздийн холбоо гээд ганцхан хүнтэй, хэзээ ч бизнес хийж байгаагүй, ардаа ямар ч бизнесийн төлөөлөл байхгүй тийм хүнийг 3 талт хэлэлцээрээр нэг этгээдээр нь оруулаад тэгээд тэр зөвлөлөөрөө дамжуулаад тодорхой хэмжээний мөнгөнүүдээ энд тэнд нөгөө хуримтлуулах данснууд банкнууд дээр байршуулах шийдвэрүүд гараад явдаг. Түүнээс болоод тэр Капитал банк дээр мөнгөө алдаж байсан. Өөр ямар ямар банк дээр мөнгөө алдлаа. Тэгээд энэ гарч байгаа Нийгмийн даатгалын хууль, тэр Хөдөлмөрийн хууль гээд бөөн будилаан байгаа шүү дээ. Тэгээд энэ Хуримтлалын сангийн юуг нь энэ тэр зөвлөл нь энэ мөнгөний хуримтлалын юун дээр нь оролцох уу, үгүй юү. Энэ дээр нэг хариу авчихмаар байна.

Мөн ихэнх энэ бүрдүүлбэр нь ашигт малтмалын юунаас явж байна л даа. Тэгэхээр бид нар энэ Ашигт малтмалын хуулиа хэзээ ер нь өргөн барих юм. Тэрийгээ нэг хэлэлцэх ёстой биш үү л гэж хараад байхгүй юу. Энэ дээр нэг асуулт хариулт авчхаад дараа нь тодруулъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэг. Ажлын хэсгийг хэдэн номер хариулмаар байна. 6 номер уу. Ажлын хэсгийн 6 номер хариулъя.

С.Наранцогт: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Эхний асуулт бол энэ стратегийн ач холбогдолтой лиценз шилжүүлэх, бэлэглэх, өв өвлүүлэх тохиолдолд 30 хувь болгоно гэсэн ийм заалтыг оруулж ирж байгаа. Одоо бол 10 хувьтай байгаа, энэ өөрчлөлт орж байгаа. Нэмэлт энэ дээр тодруулах шаардлагатай бол манай Сангийн яамны Тулга дарга энд байж байна.

2 дугаар асуулт, тэр Улс төрийн намын хуульд болохоор энэ ашигт малтмалын уурхайн салбарын компаниуд энэ улс төрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй л гэдэг ийм ганцхан өөрчлөлт орж байгаа.

Нийгмийн даатгалын энэ 2030 он хүртэл ер нь үндсэндээ энэ хуулийн энэ сангуудын төсөв, энэ сангуудын санхүүжилтийн эрх мэдэл бүгд нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэгт ороод Их Хурал дээр бүх шийдвэр гараад явна. Яг төсөв баталдаг процесстой адилхан. Тэгэхээр яамнууд нөгөө шинэ бүтэц бүрдүүлэх, энэ хооронд тухайн хөрөнгийн удирдлагын компанийн чадавхыг бүрдүүлэхийн энэ ажлаа хийхийн үед бол яамнууд зүгээр их хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх л ийм үйл ажиллагааг явуулна. Түүнээс биш энэ дээр бид нар нэр томъёонд нь ингээд оруулаад өгчихсөн. Өөрсдөө шийдвэр гаргаад, тэр зөвлөл дээр янз бүрийн шийдвэр гаргаж хэрэгжүүлэх ийм бололцоо бол байхгүй. Яг эцсийн

шийдвэрүүд д бол Их Хурал дээр гарахаар ингэж явах юм. Тэгэхээр яамнуудын эрх мэдлийн хувьд бол хязгаарлагдмал. ЗГ дээр шийдвэр ер нь эцсийн шийдвэр бол Их Хурал дээр гараад явна аа гэж ингэж ойлгох ёстой.

Ц.Цэрэнпунцаг: Сая асуусан асуулт дээр нэмээд хариулах хариулт байна уу? Байвал хэлээрэй. Байхгүй бол Ганхуяг гишүүн нэмэлт асуултаа асууя. Байхгүй бол Ганхуяг гишүүн нэмэлт асуултаа асууя.

Х.Ганхуяг: Энэ яагаад 30 хувийг асуугаад байна гэхээр 1 дүгээрт, энэ нэмэгдээд байгаа юм уу, үгүй юм уу гэдэг дээр яг тодорхой хариулт авчихмаар байна. Тэгээд энэ хайгуулын лиценз шилжүүлэхэд 30 хувь гэгчихсэн байна шүү дээ. Тэгээд одоо бол хайгуулын лицензийг шилжүүлэхэд газар доорх баялгийг нь гаргаж ирээгүй баялгийг нь олборлох боломжтой боломжгүйг нь тодорхойлохгүйгээр шууд татвар авч шилжүүлж байгаа шүү дээ. Түүн дээр ямар нэгэн өөрчлөлт орж байгаа юу, үгүй юу.

Мөн хайгуулын лиценз авахад дуудлага худалдаагаар авч байгаа, тийм ээ, 70, 80 хувь нь мөнгөн дүн тавьсан дээр нь явж байгаа байх, тийм үү. Тэгэхээр тэр дуудлага худалдаагаар авсан дүнгээс нь 30 хувь гэж явах юм уу, эсвэл тэр нөгөө газар доорх юмыг нь үнэлээд 30 хувийг нь авах гээд байна уу.

Мөн 3 дугаар асуудал болохоор энэ ашигт малтмалын хайгуулын лицензийг дуудлага худалдаагаар нэг 70 хувийн үнэлгээг нь мөнгөн дүн тавьсан юугаар нь ингээд яваад байгаа юм. Тэгэхдээ энэ дээр бас та бүхэн минь нэг эргэж харахгүй бол дотоодын компаниуд ерөөсөө авч чадахаа больчихсон шүү. Хайгуулын лиценз.

Ц.Цэрэнпунцаг: Ганбаатар сайд хариулъя. Ганбаатар сайдын микрофоныг нээе.

Ж.Ганбаатар: Тэр 30 хувь оруулж ирж байгааг бол надад огт танилцуулаагүй. Тэр стратегийн орд юм шиг байна гэдэг хариултыг бол сонслоо. Энэ оруулж ирж байгаа хүмүүс бол надад танилцуулах асуудал бол их хойшилсон шүү, Наранцогт дарга аа, 2 сар хүлээсэн шүү гэдгийг албан ёсоор хэлье.

Тэр 30 хувь дээр бол хэн Ганхуяг гишүүн ээ, ийм байгаа, энэ бол Сангийн яамны журам. Хуульд бол ямар нэгэн заалт байхгүй. Бид Сангийн яамны журамд бол Сангийн сайдтай хэлцэлд хүрээд хайгуулын тусгай зөвшөөрлийн шилжүүлэг дээр бол яг хэлцлээр нь хоорондоо шилжүүлж байгаа хэлцэл байна шүү дээ. Үүнээс нь бол 10 хувийг авна. Үүнийг бол бараг эцэслээд шийдчихсэн, 95 хувьтай бараг, А зөвшөөрөл дээр бол ашиглалтын зөвшөөрөл дээр бол харин тэр оруулсан хөрөнгө оруулалт, нөөцтэй нь холбоотой зүйлүүд бол яригдаж байгаа. Эцсийн байдлаар Сангийн яамтай манай яам арай бол тохиролцоонд хүрээгүй байна.

Зүгээр ер нь бол хөрөнгө оруулагч нар тавьж байгаа хамгийн гол асуулт бол наадах чинь. Ер нь хайгуулын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхэд бол нөөцөөс нь бодож байгаа ирээдүйд олох ашгаас нь боддог ийм зүйлүүд бол байсан. Үүнийг бол засчихсан. Ер нь бол одоогоор бол яг практик дээр бол яг хэлцлээс нь авч байгаа гэдгийг бол хэлье. Энэ засагдаад нэг 3 сар болчихсон байгаа шүү.

Тэр юуг сонгон шалгаруулалт бол ер нь манай яг түүхэнд бол ер нь хамгийн зөв хувилбар байгаад байгаа тийм ээ, нөгөө баахан очерлодог байсан, эс үгүй бол мэдээлэл юутай нь хамгийн түрүүнд авдаг байсан, эс үгүй бол том биетэйнүүд нь түрүүлээд авчихдаг байсан, эс үгүй бол сонгон шалгаруулалт бол ер нь бол харьцангуй гайгүй явж байгаа. Тэгэхдээ ер нь бол улиралдаа нэг 25, 30-ийг л зарлаж байгаа шүү дээ. Их хэмжээгээр бол зарлаж байгаа юм бол

байхгүй байгаа. Тэгээд нийт сумын 15 хувиас нь дээш гарсан тохиолдолд бол зарлахгүй байгаа. Энэ бол бас олон газруудаас зөвлөмж ирсэн. Энэ дээр бол бид нар тийм бодлого барьж байгаа гэдгийг хэлье. Ер нь бол тэгэхдээ яах вэ сонгон шалгаруулалтын журмыг бас төгс гэж бол үзэхгүй байна. Гэхдээ бусад улсуудын жишигт бол харин нийцэж очсон гэж харж байгаа.

Тэгээд цаашидаа бол амьдрал баян учраас засаад явах боломжтой байх. Одоогоор бол ер нь зүгээр яах вэ, эргээд ингээд түүхүүдээ харахад бол өнөөдрийн явж байгаа процесс бол харин ч гэж зүгээр нэг хэл амгүй тийм ээ, процесстай явж байгаа. Зарим нэг тохиолдолд хүмүүс бүр албаар будилуулж байгаа юм байна. Яагаад гэвэл цаанаа би энэ Баянхонгор аймгийн нэг жишигээ хэлье. Цаанаа энэ хулгайгаар газар ухааж байна. Тэгээд сонгон шалгаруулалтыг эзэнгүй болгох, эзэнтэй болгохгүйн тулд албаар өндөр үнэ өгөөд тэр дэнчингээ хаяад зугтаж байгаа. Ийм зүйлүүд бол байгаа. Бид нар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байгаа. Албаар таны тэр сонсогдож байгаа дүн бол ингээд зүгээр нэг юу гэдэг юм 2, 300 сая явж байхад нь албаар хэдэн тэрбум гэдэг үнэ хаяад тэгээд нөгөө дэнчин тавьчихсан байгаа шүү дээ тийм ээ, тэр дэнчингээ хаяад тэр яаж байна гэвэл тэр дуудлага худалдааг будилуулж байгаа. Тэгээд бид ... /минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Гүйцээгээд хариулчих, Ганбаатар сайд аа, гүйцээгээд хариулчих. 1 минут.

Ж.Ганбаатар: Би нэгхэн минут ярьчихъя. Тэгэхээр тийм тохиолдлууд бол байгаа. Тэгэхээр тэр ирж байгаа мэдээллүүдийг бас ялгаж салгаж ойлгоорой гэдгийг хэлье. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ганхуяг гишүүн тодруулж асуух уу. Болсон бол Оюунчимэг гишүүн асуултаа асууя. Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Нараа дарга хариулах байх. Энэ Үндэсний баялгийн санд жишээлбэл манайх өөрөө төсвөөс болоод байгалийн баялгаас тодорхой хувь гэж байна. Гаднын томоохон тэтгэврийн сангууд юм уу, том хөрөнгө оруулалтын сангууд, танай энэ Үндэсний баялгийн санд хөрөнгө оруулалт хийе, барьцаанд Засгийн газрын чинь үнэт цаас байна ч гэдэг юм уу тиймэрхүү зүйлээр явал энэ нээлттэй юү? Одоо гаднаас орж ирэх хөрөнгө оруулалт Үндэсний баялгийн сан дээр 1 дүгээрт, энэ асуулт байна.

2-т нь, энэ Үндэсний баялгийн сангийн хөрөнгө томоохон хэмжээний стратегийн ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөр энэ тэр хэрэгжүүлэх болоход шаардлагатай тохиолдолд энэ сангаас хөрөнгө татах бололцоог хуулиар нээж өгч байгаа юу эсвэл энэ нь бас хаалттай байгаа юу? Энэ 2-т л хариулт авчихъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэг 6 номер хариулъя. Наранцогт захирал.

С.Наранцогт: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ хууль маань Засгийн газрын хуралдаанд 3 удаа танилцуулагдсан. Тэгээд ер нь аль болох энэ намуудтай болоод Их Хурал дээр концепцын хувьд нэгдсэн ойлголттой болохын тулд хамгийн товч байх ийм зүйтэй гэдэг нь нэлээн хураангуй байдлаар орж ирж байгаа.

Хөрөнгө оруулалтын бодлогыг бол ЗГ тодорхойлно. Энэ тодорхойлох үед энд таны саяын асуусан асуултуудыг бол нэлээн нарийвчлан зохицуулж өгөхөөр өгч таарна. Одоогоор энэ яг таны асуусан асуулт дээр энэ хууль дээр бол ямар нэгэн тийм заалт бол орж ирээгүй байгаа. Хөрөнгө оруулалтын бодлогыг ЗГ өөрөө тодорхойлно гэдгээр ингэж хуульчилж оруулж ирсэн.

Том төслүүдийн хувьд бол Хөгжлийн сангаар л санхүүжнэ. Түүнээс сан хоорондоо бол төсөв хөрөнгө бол

шилжихгүй, Хуримтлалын сан бол иргэдийн нэрийн данс гэж ойлгож болно. Ирээдүй өв сан бол одоо байгаа яг ирээдүй өв сангаараа. Одоо байгаа Ирээдүй өв сан дээр бол гаднын нөгөө 3 А зэрэглэлийн зах зээлд бол хөрөнгө оруулах асуудал нээлттэй байгаа. Үүнийг Сангийн яам, Монголбанк бол аваад явна.

Хөгжлийн сан дээр бол яг Их Хурал дээр Хөгжлийн сангийн хөрөнгө төвлөрсөн тохиолдолд Төсвийн хөрөнгө оруулалтын хавсралтаар баталдаг шиг урт, дунд хугацаанд үүнийг бодлогын баримт бичигт тусгагдсан нийгэм эдийн засгийн чухал төслүүд, Үндэсний баялгийн сангийн төсвийн хавсралт болж батлагдахаар ингэж явна. Тэгэхээр Хөгжлийн сангаас бол ийм төслүүд нь батлагдана. Яг гаднын хөрөнгө оруулалтын сан бол орж ирэх асуудал энэ дээр бол хуульчлагдаж орж ирээгүй. Засгийн газрын хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд яригдах байх.

Ц.Цэрэнпунцаг: Одоо ингээд санал хураана.

Санал хураахын өмнө би бас 1 асуулт байна. Үүнийг бас тодруулах шаардлага байна. Энэ дагалдаж өөрчлөлт оруулах энэ ААНОАТ-ын тухай хууль дээр 30 дугаар зүйлийн 10.1 дээр ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эцсийн эзэмшигч нь хуулийн этгээдийн хувьцаа, хувь оролцоо, саналын эрхээ бэлэглэх, өв залгамжлалаар өвлүүлэх хэлбэрээр газар эзэмших, ашиглах, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн бусдад шилжүүлсэн тохиолдолд 30 хувиар гээд орчихсон байна. Энэ дээр ажлын хэсэг та нар тодруулаад тайлбар өг дөө. Энэ 30 хувь гэдэг чинь нийт уул уурхайн бизнес эрхэлж байгаа, лиценз эзэмшиж үйл ажиллагаа явуулж байгаа энэ бүх ААН-д хамаарч байгаа юм уу, эсвэл төрийн өмчтэй компаниуд стратегийн орд газрууд дээр хамаарч

байгаа юм уу. Үүнийг юуг томъёолж оруулж ирж байгаа юм бэ?

Ажлын хэсгийн 6 номер хариулъя.

С.Наранцогт: Байнгын хорооны дарга нь асуултад хариулъя. Энэ бол зөвхөн стратегийн ач холбогдолтой орд газрын тухай асуудал яригдаж байгаа юм. Энэ дээр 16 орд байгаа. Тэгээд энэ ордтой холбоотой заалт. Бусад бол уурхайн лиценз эзэмшигчид бол хамаарахгүй гэж ойлгож болно.

Ц.Цэрэнпунцаг: Энэ ажлын хэсэг дээр энэ анхны хэлэлцүүлэг хийх явцад үүнийг засаж, залруулж ажиллах хэрэгтэй байгаа шүү. Үүнийг анхаараарай. Ингээд саяын энэ дээр бол ингээд ерөнхий тодорхой бус ингээд ойлгох юм бол бүгд бүх хувьцаа уул уурхайн лиценз эзэмшигчид энэ эзэмших үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд дээр энэ хууль үйлчлэх гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр ажлын хэсгээс хариулж байгаа хариултаар бол төрийн өмчтэй стратегийн орд газруудыг эзэмшигч, лиценз эзэмшигч ийм хөрөнгө оруулагчид тийм, хувьцаа эзэмшигчид үүнийгээ өвлүүлэх юм бол 30 хувь гэж байгаа юм байна шүү дээ. Үүнийгээ бүүр тодорхой тусгахгүй бол сүүлдээ бид нар энд бас тодорхой бус байдал үүснэ шүү.

Баттөмөр гишүүн хаана байна. Саналаа хураая. Энхтүвшин гишүүн та ороод ирсэн тийм байна.

Санал хураалт, гишүүд.

Үг хэлэх гишүүд байна уу? Үг хэлэх Ганибал гишүүн. Үгүй ээ, сая асуулт асуусан юм. Үг хэлээгүй. Үгүй ээ, асуулт нь тусдаа явсан юм. Ганибал гишүүн үгээ хэлье.

Ганибал гишүүнээр тасаллаа.

Н.Ганибал: Монголын ард түмэн Үндэсний баялгийн сангийн тухай энэ хуулийг бол хүлээж байгаа. Өнөөдөр бид нар баялгийнхаа хуваарилалт, цаана нь

эргээд эдийн засгийн зөв тогтолцоог бүрдүүлэх гээд маш их шаардлагатай үйл явцууд хүлээж байна л даа. Тэгээд харамсалтай нь АН-ын бүлгийн гишүүд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг өргөн бариад нэлээдгүй хэдэн сар болж байгаа юм. Тэгээд хэлэлцэх эсэхийг нь оруулдаггүй, хэлэлцэх эсэхийн жагсаалтад оруулдаггүй. Харин МАН-ын Засгийн газраас оруулж ирж байгаа энэ хуулийг болохоор өчигдөр өргөн бариад, өнөөдөр бид бүхэн 8 цаг 30 минутад ажлын цагаасаа өмнө эрт ирээд бид нар хэлэлцээд ингээд хэлэлцэх эсэхийг нь шийдэх гээд ингээд сууж байна л даа.

Тэгэхээр юманд жоохон тэгш хандмаар байна. Аливаа асуудалд энэ хууль, дэг журам энэ Улсын Их Хурлын дэгийн асуудал энэ тэр байгаа шүү дээ, тийм ээ. Тэгээд яах вэ, зүгээр АН-ын бүлгийн гишүүдийн өргөн барьсан Үндэсний баялгийн сангийн хууль дээр бол бас олон онцлог зөв заалтууд байгаа. Тэгэхээр өнөөдрийн энэ өргөн барьсан хууль 2-ыг бас нийлүүлээд, тэгээд сайжруулаад, ингээд батлаад явбал болно. Тийм учраас хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Ганибал гишүүн үг хэлээд гишүүд ингээд саналаа хэлж дууслаа.

Ингээд санал хураалт явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд нь хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг танилцуулна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дууслаа.

Өнөөдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ